

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.05.09

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 05 сарын 09


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,099	0.516%	8.807%	8.766%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.516 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банк интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаа тул ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 82 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкнууд 2 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах, 10 сая ам.доллартай тэнцэх своп хэлцэл байгуулах санал ирүүлсэн ч Монголбанк биелүүлээгүй байна.



Гадаад худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт БНХАУ-ын Гаалийн ерөнхий газраас нүүрсний импортын тарифаа түр хугацаанд цуцалж байгаагаа мэдэгдсэн. Тариф буурснаар нүүрсний экспортын зардал тонн тутамд 60 юаниар буурах төлөвтэй байна. 5 сард Гашуун сухайт-Ганц мод хилийн боомтоор өдөрт дунджаар нүүрс тээвэрлэлтийн 340 автомашин нэвтэрсэн байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 5 сарын 9

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	103.915	0.27%	3.89%	15.22%
EURUSD	1.0518	-0.28%	-3.26%	-13.26%
USDCNY	6.6667	0.09%	4.82%	3.93%
USDRUB	69.4025	-2.19%	-8.78%	-6.66%
USDJPY	130.86	0.55%	5.25%	20.29%
AUDUSD	0.7022	-0.31%	-5.78%	-10.29%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүг 50 нэгжээр нэмэгдүүлж 1 хувьд хүргэлээ. Мөн үүний зэрэгцээ Холбооны нөөцийн сангийн балансыг бууруулахын тулд 6 сараас эхлэн зах зээлд худалдан авсан байгаа бондуудыг нийлүүлж мөнгөний нийлүүлэлтийг татах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдлээ
- АНУ-ын 10 жилийн хугацаат бондын өгөөж 3 хувийг давснаар мөнгөний урсгал өөрчлөгдөж ам.долларын эрэлт нэмэгдэх нөхцөл болж байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 9/May/2022 - 2:15:06 GMT. Powered by TradingView.
US Dollar Index Futures, (CFD):DX, D



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.